

**МОНГОЛ УЛС, ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНД
БАЙГУУЛАХ "ЗҮРХ СУДАСНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ БАЙГУУЛАХ ТӨСӨЛ"-ИЙН
ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ ТӨСВИЙН
БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 10 дугаар
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах "Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн дагуу Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороод 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хамтарсан хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэгт заасны дагуу зээлийн хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлснийг нэгтгэн хэлэлцсэн.

Зээлийн хэлэлцээрийн төслийг Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг зээлийн хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, Зүрх судасны үндэсний төв байгуулахад шаардлагатай төсөв, санхүүгийн тооцооллуудыг хэр бодитой, үндэслэлтэй хийсэн, мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагатай уялдуулан зээлийн ашиглалтыг хэвийн явуулах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар үнэ ханшийн өөрчлөлт, эмнэлгийн зөвшөөрөл зэрэгтэй холбоотой эрсдэлүүдийг тооцоолсон эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, эмнэлгийн орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг сонгон худалдан авах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар зүрх судасны чиглэлийн сургалт, судалгааны төв хэлбэрээр ажиллах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр төрөлжсөн эмнэлэг бий болсноор хэчнээн хэмжээний ажлын байр шинээр бий болж, шинэ эмчилгээ нэвтрүүлэх, техник, эдийн засгийн үнэлгээг шинэчилж, магадалгаа хийсэн эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал зүрх судасны өвчин үүсэх үндсэн шалтгаануудын талаар тодруулж, төсөл хэрэгжсэнээр тус эмнэлэгт ачаалал нэмэгдэх эсэх, санхүүжилтийн талаар болон эрүүл мэндийн салбарыг либералчлах талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд эмнэлэг баригдсанаар зүрх судасны өвчлөлтэй холбоотой нас баралтын тоо, гадаадад эмчлүүлж байгаа иргэдийн зардал одоогийн түвшнээс хэчнээн хувиар буурах, бүсчилсэн хөгжлийн хүрээнд цаашид бусад бүс нутагт төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг эрүүл мэндийн даатгалын удирдлагын тогтолцоог сайжруулах, нэгдсэн эмнэлгийг түшиглэн зүрх судасны хавдрын өвчлөлийг эмчлэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр төслийг хэрэгжүүлэхэд дотоодын барилгын компанийн оролцоог хангаж, дэмжих, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат төслийг зөвшилцөх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлттэй холбоотойгоор санхүүгийн тооцооллыг танилцуулах, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар аймаг, орон нутгийн эмч нарыг тус эмнэлгийн техник,

тоног төхөөрөмжтэй танилцах, сургахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, цаашид төслийн хэрэгжилтэд хяналт тавих, хөрөнгө оруулалт, худалдан авалтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг гадаадын өр, зээлийн үр ашгийг тооцоолох, уг төслийг хойшлуулах, эрүүл мэндийн даатгалын удирдлагын тогтолцоог боловсронгуй, оновчтой болгох шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат уг төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх, нарийн мэргэжлийн эмч, сувилагч нарын цалин хөлсний асуудал болон аймаг, орон нутгийн эмч нарыг бэлтгэх, дадлагажуулах, хамтран ажиллахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн төслийн зээлийн эргэн төлөлтөд анхаарах, хиймэл оюун ухааны хөгжилтэй уялдуулан орчин үеийн тоног төхөөрөмжийг худалдан авах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг чадавхжуулах, санхүүжилтийн тогтолцоог зөв, оновчтой болгох, оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийн түрээсийг судалж, хэрэгжүүлэхэд анхаарах талаар үг хэлсэн болно.

Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах "Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгов.

